



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 06

Баянбулаг

Г Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл
сонгон шалгаруулах хорооны
бүрэлдэхүүн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Суманд үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодоор дамжуулан ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор төсөл сонгон шалгаруулах хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга: М.Чинбат (Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Д.Энхтөр (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Гишүүдэд: Т.Одмаа (Орон нутаг хариуцсан нягтлан бодогч)

Х.Одончимэг (Сумын ҮЭХ-ны дарга)

Б.Хулганаа (иргэний төлөөлөл)

2.“Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-д нийцүүлэн төсөл сонгон шалгаруулах хороог удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг дарга (Н.Гансүх)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГАА Б. НАМГАРРЕНЧИН

648803016